



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

7
АНГИ

ХИМИ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:


САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу балын харандаагаар будаарай.


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

1. Зурагт ямар төлөв байдалтай бодисын жижиг хэсгийг дүрслэн үзүүлсэн байна вэ?


- A. шингэн B. хатуу C. хий D. плазма



2. Нэгэн бодис ууршжээ. Аль нь жижиг хэсгийн онолоор төлөвийн өөрчлөлтийг зөв дүрсэлсэн байна вэ?



3. Машины дугуйг азот хийгээр хийлдэг. Машины дугуйн доторх азотын хийн жижиг хэсгүүдийг үзүүлэв. Аль дугуйнд жижиг хэсгийн онолоор азотын даралт бага байх вэ?




4. Доор өгөгдсөн жишээнүүдээс хийн диффузийн жишээ хэд байгааг сонгоорой.

усанд кофе найруулах, агааржуулагч үнэртэх, давс уусгах, хоол үнэртэх, шүүс найруулах, утаа үнэртэх, цас орох

- A. 1 B. 2 C. 3 D. 4

5. Нэгэн хийг удаанаар хөргөхөд гарах өөрчлөлтийн температур хугацаанаас хамаарсан графикийг харуулав. Аль хэсэгт хатуу болох төлөвийн шилжилт явагдаж байгаа вэ?



6. Магнийн химийн тэмдгийг сонгоорой.

- A. Mn B. Mg C. Mo D. Md

7. Металл бишүүд нь хайлах, буцлах цэг бага, нягт багатай байдаг. Доорх хүснэгтэд химийн 4 элементийн шинж чанарыг үзүүлэв. Аль элемент нь металл биш вэ?

	хайлах цэг / °C	буцлах цэг / °C	нягт / г·см ⁻³
A	98	890	0.971
B	180	1342	0.534
C	-101	-34	0.0032
D	-39	356	13.5

8. Зургийг ажиглаад төгсгөлд нь химийн элемент, нэгдэл, холимгийн аль нь үүссэн болохыг тодорхойлоорой.



- A. элемент B. холимог C. нэгдэл D. холимог, нэгдэл

9. Шилэн аяганд байгаа чихэртэй усыг буцалгаж, ус нь бүрэн ууршиж дуусахад шилэн аяганы ёроолд хуурай үлдэгдэл үлдэв. Дараах зүйлсийн аль нь шилэн аяганд үлдсэн гэж хэлж болох вэ?

- A. элемент B. холимог C. нэгдэл D. усны уур

10. Байгальд хүдэр хэлбэрээр оршдог, цахилгаан дамжуулагч бөгөөд барилга барих, хашлага хийхэд хэрэглэдэг, соронзлогддог бол энэ химийн элементийг олоорой.

- A. алт B. зэс C. мөнгө D. төмөр

11. Дараах холимгуудаас алийг нь ууршуулах аргаар ялгаж болох вэ?

- A. ус ба давс B. ус ба шороо
 C. ус ба модны үртэс D. ус ба спирт

Анхаараарай !!!

Давсны хүчил дээр цайр нэмжээ. Уг өгөгдлийг ашиглан 12, 13 – р асуултад хариулаарай.

12. Дээрх урвал явагдах үед температур өөрчлөгдөж, хий ялгардаг. Энэ үед ямар үзэгдэл явагдсан бэ?

- А. хайлах үзэгдэл
 В. физикийн үзэгдэл
 С. шингэрэх үзэгдэл
 D. химийн үзэгдэл

13. Явагдсан үзэгдлийн химийн урвалын үгэн тэгшитгэлийг сонгоно уу.

- А. цайр + давсны хүчил → цайрын хлорид
 В. цайр + давсны хүчил → цайрын хлорид + устөрөгч
 С. цайр + давсны хүчил → цайрын хлорит
 D. цайр + давсны хүчил → цайрын хлорит + устөрөгч

14. $pH > 7$ уусмалд фенолфталеин 3 дуслыг хийж хутгав. Уусмалын өнгө ямар болж өөрчлөгдсөн бэ?

- А. ягаан
 В. улаан
 С. өнгөгүй
 D. шар

15. Устөрөгчийн хлоридын уусмал дээр метилоранжийн индикатороос хэдэн дуслыг дусааж илүүдэл калийн гидроксидын уусмал нэмжээ үүссэн уусмал ямар өнгөтэй болох вэ?

- А. өнгөгүй
 В. ягаан
 С. шар
 D. улаан

16. Төмрийг зэврэлээс хамгаалахын тулд аль аргыг хэрэглэж болох вэ?

- А. буцалсан усанд хийх
 В. чийгтэй газар тавих
 С. давстай усанд хийх
 D. тослох

17. Төмөр (хадаас) – ийн зэврэлийг турших нөхцөлүүдийг зурагт харуулжээ. Аль нөхцөлд төмөр хадаас зэврэхгүй вэ?

А. 1 ба 2
 В. 1 ба 3
 С. 1 ба 4
 D. 2 ба 4

18. Доорх хүснэгтэд газар зүйн байршил болон далайн түвшнээс дээш өргөгдсөн өндөр /м/ – ийг харуулав. Аль газар зүйн байршилд усны буцлах цэг их байх вэ?

	Газар зүйн байршил	Далайн түвшнээс дээш өргөгдсөн өндөр /м/
A	Алтай хот	2181
B	Улаанбаатар хот	1350
C	Хөх нуурын хотгор	532
D	Таван богд уулын Хүйтэн оргил	4374

19. Нүхэн жорлон нь байгаль бохирдуулагч учраас түүнээс үүсэх бохирдлыг багасгах янз бүрийн аргыг санал болгодог. Нүхэн жорлонг бохирын саваар орлуулан зориулалтын газар зөөвөрлөн аваачиж асгадаг нь ямар төрлийн бохирдлоос хамгийн ихээр сэргийлж чадах вэ?

- A. хөрсний бохирдол
B. агаар дахь тоосонцрын хэмжээ
C. гадаргын усны бохирдол
D. голын усны бохирдол

20. Хөрсний найрлага дахь усны гүйцэтгэх үүргийг сонгоно уу.

- A. хөрсний хатуу хэсгийг бүрдүүлдэг
B. ургамалд шим тэжээлт бодисыг зөөвөрлөнө
C. ургамал, амьтныг амьсгалах нөхцөлөөр хангана
D. ургамлын шим тэжээл, бусад организмын эх сурвалж болох